НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас/Факс: (976-11) 32-71-99, http://www.ulaanbaatar.mn

2017.06.16 № 04/2322

танай ________ -ны № ________ -т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Нэгтгэж Судлаж танилцуулах ... 2017.06.19

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталж, улсын хэмжээнд хэрэгжүүлж ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г батлан хүргүүлж байна.

Дээрх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг өөрийн болон салбар байгууллагын хэмжээнд зохион байгуулж, тайланг 2017 оны 10 дугаар сарын 30-ны дотор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ үү.

Төлөвлөгөөг хавсаргав.

Хавсралт..9..хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ү.ГАНБОЛД

ТГБ 2105

111020002293

391

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 13 өдөр Дугаар А/429 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 23/01 дүгээр, 2016 оны 6/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг нийслэлийн 2017 оны төсөвт тусгасан холбогдох зардлаас гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ С.БАТБОЛД

11102000 1947

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/429 дугаар захирамжийн хавсралт

# НИЙСЛЭЛИЙН 2017 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зорилт | Арга хэмжээний дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэгч байгууллага | Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/ | Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг.Хуулиар хүлээсэн үүрэг, удирдлага зохион байгуулалт, төрийн хяналт шалгалт, төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр** | | | | | | | |
| 1 | Нийслэлийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдан зохицуулах, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих | 1 | Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг (33) харьяа байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангаж, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | Жилдээ | НЗДТГ | - | Мэргэшлийн удирдлагаар хангаж, зөвлөгөө, заавар, зөвлөмж хүргүүлсэн байна |
| 2 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-уудыг мэдээ, мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах | 2 | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан ЭБАТ-ныг мэдээлэл арга зүйгээр хангах, хөтөлбөрийн талаар мэдээлэл, танилцуулга хийнэ. | Жилдээ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | - | Авлигатай тэмцэх газар, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, эрх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүхий албан тушаалтнууд хөтөлбөрийн талаар мэдээлэлтэй болсон байна. |
| 3 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрийн ил тод, байдлыг хөндлөнгийн шинжээчээр үнэлүүлэх, үнэлгээний дүнг олон нийтэд танилцуулах, гарсан зөвлөмж, чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | 3 | Иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна. | 3 дугаар улирал | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 10.0 | Үнэлгээ хийгдсэн байна. |
| 4 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах, авлигын эсрэг сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах | 4 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээ мэдээлэл, гарын авлагаар хангана. | Жилдээ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газар,Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд | 4.0 | Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг сурталчилсан байна. |
| 5 | Төрийн хяналт шалгалтын ил тод нээлттэй байдлыг хангах | 5 | Тухайн жилд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад явуулах хяналт шалгалтын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г баталж, цахим хуудаст байршуулна. | 1 дүгээр улиралд | НЗТГ-ХШҮХ Нийслэл, Дүүргийн Дотоод аудитын алба | - | Хяналт шалгалтын бэлтгэл бүрэн хангагдсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 6 | Хийсэн хяналт шалгалтын дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. | Жилдээ | НЗТГ-ХШҮХ Нийслэл, Дүүргийн Дотоод аудитын алба | - | Мэдээлэл иргэдэд хүрсэн байна. |
| 6 | Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг хуулийн хугацаанд цахим хуудаст тухай бүр мэдээлэх | 7 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангана. | Жилдээ | ННЗБ-ууд | - | Санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл нээлттэй болсон байна. |
| | | 8 | Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлнэ. | Жилдээ | ННЗБ-ууд | - | Санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл нээлттэй болсон байна. |
| | | 9 | Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, зарцуулалтыг цахим хуудас бусад хэлбэрээр мэдээлж иргэн, байгууллагын мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлнэ . | Жилдээ | Дүүргүүдийн ЗДТГ | - | Тухай жилд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил үйлчилгээний нэр, хийгдсэн ажлууд, хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл нээлттэй болсон байна. |
| 7 | Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг нээлттэй болгох | 10 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу олгох, давхардлыг арилгах, хяналт | Жилдээ | Тусгай зөвшөөрөл олгож буй байгууллагууд | - | Тусгай зөвшөөрөл олгох шат дараалал цөөрч, зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээлэл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгалтыг тогтмол зохион байгуулах | | | | нээлттэй болсон байна. |
| | | 11 | Тусгай зөвшөөрөл олгох журам, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, эхлэх болон дуусах хугацааг олон нийтэд нээлттэй мэдээлнэ. | Жилдээ | Тусгай зөвшөөрөл олгож буй байгууллагууд | - | Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэл нээлттэй болсон байна. |
| **Хоёр. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, хамтын ажиллагааг бэхжүүлэх** | | | | | | | |
| 8 | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 12 | Хөтөлбөрийг иргэд, олон нийт, төрийн байгууллага, албан хаагчдад сурталчлах, сурталчилгааны материалыг бэлтгэж түгээнэ. | 2 дугаар улиралд | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 5.0 | Хөтөлбөрийн зорилтыг танилцуулсан байна. |
| | | 13 | Төрийн захиргааны төв байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг хандалт өндөртэй үйлчилгээнүүдийг Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлэх замаар засаглалын /үйлчилгээний/ ил тод, нээлттэй, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ. /бэхжүүлэх/ | Жилдээ | ТЗУХ, НҮНТ | Холбогдох зардлаас | Үйлчилгээ авах шат дараалал цөөрч, төрийн үйлчилгээг нэг дороос авах боломж нэмэгдсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 14 | Шийдвэр гарах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, тэднийг мэдээллээр хангах, нийслэлд тулгамдаж буй асуудал, зарим хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зөвлөлдөх ардчиллын зарчмаар шийдвэрлэн, нийтийн сонсголыг зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын дэргэд Экспертүүдийн зөвлөл ажиллуулна. | 2 дугаар улиралд | НЗУХ, НИТХ-ын Иргэний оролцооны хэлтэс | Төслийн үйл ажиллагааг сурталчлах зардлаас | Нийслэлийн удирдлагаас батлагдан гарч байгаа шийдвэрт иргэдийн санал тусч, экспертүүдийн зөвлөл байгуулагдсан байна. |
| 9 | Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Ил тод Улаанбаатар академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг үргэлжлүүлэх | 15 | Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвүүдийн үйл ажиллагаанд мониторинг хийлгэх, үр дүнг үр ашигтай хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлнэ. | 1,2 дугаар улирал | ТЗУХ | 10,0 | Төвийн үйл ажиллагааг сайжруулах, үйлчилгээний чанар, стандартыг нэмэгдүүлэх ажил хийгдсэн байна. |
| | | 16 | Авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Жилдээ | ННЗБ-ууд, ОУ-ын байгууллагууд | - | ННЗБ-ууд, олон улсын байгууллагын хамтын ажиллагаа бэхэжсэн байна. |
| 10 | Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах | 17 | Нийслэлийн удирдлагаас хэрэгжүүлж байгаа тодорхой төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, явц байдалд судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | Жилдээ | ТЗУХ, ТББ-ууд | 10.0 | Төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц тодорхой болсон байна |
| | | 18 | Авлигатай тэмцэх асуудлаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын | 4 дүгээр улиралд | ТЗУХ, ОУБ, ТББ-ууд | 10,0 | Сургалт, хэлэлцүүлэг зохион |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судлаач, эрдэмтдийг урьж сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. | | | | байгуулагдсан байна. |
| | | 19 | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, чиглэлээр нийслэлийн хэмжээнд “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2 дугаар улиралд | ТЗУХ | 8,0 | Зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан байна. |
| 11 | Албан хаагчдын шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх | 20 | Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын нийгмийн хор уршгийг албан хаагчдад ухуулан таниулах, төрийн албан хаагчдад шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар ойлголт өгөх сургалтыг зохион байгуулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ёс зүйн хороодыг чадваржуулах, үйл ажиллагаанд нь удирдлага арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | 1 дүгээр улиралд | ТЗУХ | 3.0 | Ёс зүйн хорооны гишүүдэд сургалт зохион байгуулсан байна. |
| | | 21 | Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг олон эх үүсвэрээр хүлээн авч шуурхай шийдвэрлэж мэдээлнэ. | Жилдээ | ТЗУХ,НҮНТ | - | Зөрчлийн мэдээг нэгтгэн ТАЗ-д хүргүүлсэн байна |
| | | 22 | Авлигын эсрэг боловсрол олгох хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага, судлаачидтай хамтран боловсруулж, албан хаагчдыг хамруулна. | Жилдээ | ТЗУХ, Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим | - | Хөтөлбөр батлагдсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 23 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтны ёс зүйн мэдэгдлийг гаргуулна | 1 дүгээр улиралд | ТЗУХ | - | Ёс зүйн зөрчилгүй ажиллахаа илэрхийлж ёс зүйн мэдэгдэл гаргасан байна. |
| **Гурав. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын оновчтой бүтцийг бий болгох, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх** | | | | | | | |
| 12 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” (KPI)-ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл, хяналт, удирдлагын нэгдсэн санг бий болгох | 24 | Хүний нөөцийн бүртгэл, хяналт, удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт" (KPI)-ээр үнэлэх аргачлалыг батлуулж, үр дүнг тооцож ажиллана. | Жилдээ | ТЗУХ | “Аж жаргалтай хот” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө, өөрийн батлагдсан хөрөнгө | Нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” (KPI)-ээр үнэлж дүгнэсэн байна. |
| | | 25 | Улаанбаатар хотын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, бүтээн байгуулалтын ажилд иргэдийн оролцоо, залуучуудын мэргэжил боловсрол, мэдлэг чадварыг татан оролцуулах зорилгоор “Нээлттэй ажлын байр” өдөрлөгийг зохион байгуулна. | 1 дүгээр улиралд | НЗДТГ, ННЗБ-ууд | - | Нээлттэй ажлын байр сурталчлах өдөрлөгийг зохион байгуулсан байна. |
| 13 | Төрийн захиргааны оновчтой бүтцийг бий болгох, ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн албан хаагчдын үр чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх, төрийн үйлчилгээг цахим | 26 | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, дүүргийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлж, хороодоос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Жилдээ | НЗДТГ, ННЗБ-ууд | - | Төрийн зарим үйлчилгээ хороодод шилжиж хороодоос үзүүлэх үйлчилгээний төрөл нэмэгдсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрт шилжүүлж, төрийн албыг хариуцлагатай, хяналттай, ухаалаг болгох | 27 | Хууль тогтоомж болон төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг зөрчин бусдад хохирол учруулсан албан тушаалтан хохирлыг өөрөө хариуцан төлж барагдуулах, өөрт ногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг өөрийн зардлаар нийтэд мэдээлэх журам хэрэгжүүлнэ. | Жилдээ | ТЗУХ | - | Зөрчлийн талаарх мэдээ нийтэд ил тод болсон байна. |
| | | 28 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцох, хяналт тавих тогтолцоог бий болгож, нээлттэй засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ. | Жилдээ | ТЗУХ, НҮНТ | - | Уулзалтын хуваарь батлагдаж, иргэдтэй хийх уулзалт тогтмолжсон байна. |

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮРГҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗАР
АРХИВЫН ГАЗАР
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
БОЛОВСРОЛЫН ГАЗАР
ГАЗРЫН АЛБА
ГЭР ХОРООЛЛЫН ДЭД БҮТЦИЙН ГАЗАР
ДОТООД АУДИТЫН АЛБА
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР
МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ГАЗРЫН АЛБА
НИЙСЛЭЛИЙН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО
УЛААНБААТАР ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР
СТАТИСТИКИЙН ГАЗАР
ТАТВАРЫН ГАЗАР
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ҮЙЛДВЭРЛЭЛ, ИННОВАЦИЙН ГАЗАР

БАГАНУУР ДҮҮРЭГ
БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ
БАЯНГОЛ ДҮҮРЭГ
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ
НАЛАЙХ ДҮҮРЭГ
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ
СҮХБААТАР ДҮҮРЭГ
ХАН-УУЛ ДҮҮРЭГ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС;
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС;
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС;
ГАДААД ХАРИЛЦААНЫ ХЭЛТЭС;
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС;
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС;
ЦЭРГИЙН ШТАБ.